



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 1/304

Номгон

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Эрдэнэцогт, Галуут сумдад хэрэгжих Хангайн бүсийн уулын ландшафтыг нөхөн сэргээж, хамгаалах замаар экосистемийн үйлчилгээ болон орон нутгийн иргэдийн амжиргааг сайжруулах нь "ХАНГАЙ" төслийн олон талт оролцоог хангаж ажиллах, хяналт тавих ажлын хэсгийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө болон сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хоорондын уялдааг хангах, хэрэгжилтэд хяналт тавих үр дүнг олон нийтэд хүргэж төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг Ажлын хэсгийн дарга Засаг даргын Орлогч (Б.Наранбаяр), Эрдэнэцогт сумын Засаг дарга (Б.Энхбаатар), Галуут сумын Засаг дарга (Л.Батсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тус төслийн хүрээнд ашиглагдах суурь судалгаа, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг боломжит эх үүсвэрээс орон нутгийн төсөвт тусгах саналыг боловсруулж аймаг, сумдын Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4.Зохион байгуулсан ажлын явцыг олон нийтэд нээлттэй хүргэж, хяналт мониторинг хийсэн ажлын үр дүнг жил бүр аймгийн Засаг даргад танилцуулахыг Ажлын хэсэгт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Г.Энхбаяр)-т даалгасугай.

ДАРГА

Э.ЭНХБАТ

626010839

Аймгийн Засаг даргын 2006 оны 5 дугаар сарын
19-ний өдрийн 11/307 дүгээр захирамжийн
01 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Б.Наранбаяр

Аймгийн Засаг даргын Орлогч

Нарийн бичгийн дарга:

Х.Сонинбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон
нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн
хэлтсийн Байгаль орчин, газрын харилцаа, уул
уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Л.Батсайхан

Галуут сумын Засаг дарга

Б.Энхбаатар

Эрдэнэцогт сумын Засаг дарга

Б.Бат-Өлзий

Байгаль орчны газрын дарга

Т.Эрдэнэбат

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Ням-Очир

Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны
дарга

Г.Нансалмаа

Их Богдын байгалийн цогцолборт газрын
хамгаалалтын захиргааны дарга

А.Батаа

Сум дундын Ойн ангийн дарга

А.Цэцэнбилэг

Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын Удирдлагын хэлтсийн дарга

Д.Номин

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн
бодлогын хэлтсийн Хөдөлмөр эрхлэлтийн асуудал
хариуцсан мэргэжилтэн

А. Уянга

Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг
WCS (PhD) Нөхөн сэргээлт, биологийн олон янз
байдал хариуцсан мэргэжилтэн

Д.Цэвэгдорж


Эрдэнэцогт сумын Орон нутгийн зохицуулагч

Б.Энхзаяа

Галуут сумын Орон нутгийн зохицуулагч

.....оОо.....

Аймгийн Засаг даргын 2006 оны 5 дугаар сарын
19-ний өдрийн А/304 дүгээр захирамжийн
02 дугаар хавсралт



УДИРДАМЖ

Нэг.Зорилго

Эрдэнэцогт, Галуут сумдад хэрэгжих Хангайн бүсийн уулын ландшафтыг нөхөн сэргээж, хамгаалах замаар экосистемийн үйлчилгээ болон орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах нь "ХАНГАЙ" төслийн олон талт оролцоог хангаж ажиллах, хяналт тавих, мониторинг хийх, төслийг үр дүнтэй хэрэгжүүлэх

Хоёр. Зохион байгуулах арга хэмжээ

Ландшафтын нэгдмэл төвшинд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт-мониторинг хийх болон сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд хяналт мониторинг хийх, үр дүнг олон нийтэд хүргэх аймгийн салбар дундын, олон талт Ажлын хэсэг нь дараах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.Экосистем, газрын доройтол, биологийн олон янз байдлыг харгалзан боловсруулж буй аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хяналт-мониторинг тогтмол хийх;

2.2.Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ жөндөрийн мэдрэмжтэй, талуудын тэгш оролцоог хангах замаар экосистем, газрын доройтол, биологийн олон янз байдлыг харгалзсан эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, батлагдсан аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах, холбогдох арга хэмжээний зардлыг дараа оны орон нутгийн төсөвт тусгуулах;

2.3.Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн төлөвлөгөө, хамгаалалтын дэглэм, горимтой сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, усны сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөгөөг уялдуулан хэрэгжилтийг хангах ажилд хяналт тавихад оршино.

Гурав. Ажлын зохион байгуулалт

3.1.Ажлын хэсэг улиралд 1 удаа батлагдсан хуваарь, төлөвлөгөөний дагуу

хуралдаж, үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэх, санал солилцох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зөвлөмжийг Засаг даргын өгсөн чиглэлийн дагуу холбогдох албан тушаалтанд хүргүүлэх байдлаар ажиллана.

3.2.Ажлын хэсгийн гишүүдээс гарсан саналыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нэгтгэн хурлын тэмдэглэлд тусгаж, ажлын хэсгийн даргаар баталгаажуулан сумын Засаг даргад танилцуулна.

3.3.Ажлын хэсгээс гарсан санал, зөвлөмжийг сумын Засаг даргад танилцуулсны дагуу хамтын шийдэл бүхий санал, зөвлөмж гаргах зааврын дагуу ажлын хэсгийн ахлагч, холбогдох албан тушаалтанд чиглэл өгнө.

Дөрөв. Үр дүнг танилцуулах

4.1.Ажлын хэсэг аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө, тусгай хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө, усны сав газрын нэгдсэн менежментийн төлөвлөгөө, ойн менежментийн төлөвлөгөөний уялдааг хангасан хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн тайланг улирал бүр сумын иргэд, олон нийтэд хурал, уулзалт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан боломжит бүх төрлийн арга хэлбэрээр танилцуулж ажиллана.

.....оОо.....